



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 07 сарын 06 өдөр

Дугаар А/Б/43

Мандалговь

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 5.1.3 дахь заалт, Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а", Монгол Улсын Их Хурлын 2017 оны 39 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг орон нутгийн хэмжээнд хэлэлцүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч – Аймгийн Засаг даргын орлогч

Орлогч дарга – Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга /Зөвшилцсөнөөр/

Нарийн бичгийн дарга - Аймгийн ИТХ-ын ажлын албаны ажилтан

Гишүүдэд: Аймгийн ЗДТГ-ын дарга

Аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-ийн дарга

Аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ-ийн дарга

Аймгийн ИТХ-ын ажлын албаны ажилтан

Аймгийн Шүүхийн тамгын газрын дарга /Зөвшилцсөнөөр/

Сайнцагаан сумын ИТХ-ын дарга /Зөвшилцсөнөөр/

Хоёр. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн талаар сум орон нутгийнхаа иргэдийн дунд уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулахад шаардлагатай дэмжлэг үзүүлж, зохион байгуулалтаар ханган, Үндсэн хууль батлалцахад оролцсон депутатуудтай хамтарч ажиллахыг сумын Засаг дарга нарт даалгасугай.

Гурав. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн талаар орон нутгийн иргэдийн дунд уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулан, гарсан санал, дүгнэлтийг нэгтгэн боловсруулж Улсын Их Хурлаас байгуулсан ажлын хэсэгт 2017 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор хүргүүлсүгэй.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ



0200702